



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 05 сарын 17 өдөр

Дугаар А/91

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар Ховд аймгийн Жаргалант сумын Жаргалан багийн нийтийн байрны дээвэр, фасад, орцны засвар, тоглоомын талбай байгуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороо дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд

- Дарга: Н.Эрдэнэцэцэг - Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн
- Гишүүд: Ц.Өсөхбаяр - Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын ерөнхий нягтлан бодогч
- Г.Сүнжидмаа - Хувийн хэвшлийн төлөөлөл
- М.Энхболд - Иргэний төлөөлөл
- Нарийн бичгийн дарга: Х.Дэмид - Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /Н.Эрдэнэцэцэг /-нд үүрэг болгосугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Х.Дэмид /-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД

2019-тг А/91 Ch
02 00408